

## ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД БАРАА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны ... сарын ...-ны өдөр

№....

Улаанбаатар хот

Энэхүү бараа Зочлох үйлчилгээний байгууллагад бараа нийлүүлэх гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ Монгол Улсын Иргэний хууль холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн

Нэг талаас 5371775 регистрийн дугаартай “НЬЮ КЛЕОС” ХХК, түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ...../цаашид “Худалдагч” гэх/

Нөгөө талаас ..... регистрийн дугаартай “.....” ХХК, түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ..... /цаашид “Худалдан авагч” гэх/ нар доорх нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Худалдагч нь Зочид буудал, зоогийн газрын зориулалттай [www.hundaga.mn](http://www.hundaga.mn) онлайн дэлгүүрт худалдаалж буй ХБНГУ-н Штолзле (Stoelzle) брэндийн шилэн эдлэл /цаашид “бараа” гэх/-г Худалдан авагчид онлайн дэлгүүрийн үнээс байнгын 20%-н хямдралтай үнээр нийлүүлж, түүний өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч тал нь барааны төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Худалдан авагч нь энэ гэрээний нөхцлөөр худалдан авалтыг зөвхөн дараах ажилтны нэр, имэйл хаягнаас хийнэ:  
Нэр:  
Имэйл:
- 1.3 Худалдагч барааны үнийг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор барааг Худалдан авагчийн хаягт хүргэж өгч, бараа хүлээлцсэн акт үйлдэнэ.
- 1.4 Гэрээ нь талууд харилцан зөвшөөрч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс эхлэн 18 / 24 (тохирохыг доогуур зурна) сарын хугацаанд хүчинтэй.
- 1.5 Гэрээнд худалдан авагч талын зочлох үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хуулбарыг хавсаргана.

### ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1 Худалдан авагч барааны үнийг барааг хүлээн авахаас өмнө Худалдагчийн ХААН банкны 5003539758 тоот дансанд шилжүүлсэн байна.
- 2.2 [www.hundaga.mn](http://www.hundaga.mn) дэлгүүрт үлдэгдэлгүй барааг захиалгаар нийлүүлэхээр тохирсон бол захиалгын хуудсаар төлбөрийн нөхцлийг нэмэлтээр тохирох ба уг захиалгын хуудас нь энэ гэрээний салшгүй хэсэгт тооцогдоно.

### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 3.1 Худалдагчийн эрх, үүрэг

- 3.1.1 Худалдагч нь Худалдан авагчаас гэрээний төлбөрийг тохирсон хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй бөгөөд хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алданги, торгууль тооцох эрхтэй.
- 3.1.2 Худалдагч нь Худалдан авагчид зохих чанар, стандартын шаардлага хангасан, эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй, чанартай барааг худалдах үүрэгтэй.
- 3.1.3 Барааг актаар хүлээн авах үед гэмтэлтэй, чанарын доголдолтой, гэмтэлтэй байсан тохиолдолд өөрийн зардлаар засах буюу ижил төрлийн бараагаар худалдан авагчийн шаардлагын дагуу солих үүрэгтэй
- 3.1.4 Худалдагч нь зөвхөн гэрээнд заасан Худалдан авагчийн итэмжлэгдсэн ажилтанд ажлын үнэмлэх бичиг баримтыг шалгасны үндсэн дээр барааг хүлээлгэн өгнө.
- 3.1.5 Худалдаж байгаа барааны тээврийн зардлыг хариуцан хүргэж, хүлээлгэн өгөх.

Худалдалдагчийг төлөөлж

Худалдан авагчийг төлөөлж

### **3.2 Худалдан авагчийн эрх, үүрэг**

- 3.2.1 Чанар, стандартын шаардлага хангаагүй, биет байдлын доголдолтой, эрхийн зөрчилтэй барааг хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 3.2.2 Барааг хүлээн авах хагарсан, цуурсан, үйлдвэрлэлийн гологдолтой бараа байгаа эсэхийг бүрэн шалгах үүрэгтэй ба чанар, биет байдлын шаардлага хангаагүй барааг солиулан авах эрхтэй.
- 3.2.3 Гэрээний 1.2-т заасан ажилтан өөрчлөх бол худалдан авалт хийхээс өмнө Худалдагч талд мэдэгдэх үүрэгтэй.
- 3.2.4 Худалдан авсан барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх.

### **ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА**

- 5.1 Гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талдаа учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна.
- 5.2 Худалдан авагч нь төлбөр төлөх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.2 хувийн алданги төлнө.

### **ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 6.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер усны аюул, гал түймэр, дайн байлдаан, бослого, хөл хорио, террорист үйлдэл, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн саймуун гэх мэт нөхцөл байдал)-ийн шууд болон шууд бус нөлөөний улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөх ба гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хугацаагаар хойшлуулж болно.
- 6.2 Хэрэв давагдашгүй хүчин зүйл хуанлийн 30 хоног болон түүнээс дээш хугацаагаар үргэлжилбэл талууд гэрээг цуцлах эрхтэй.

### **ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭ ЦУЦЛАХ НӨХЦӨЛ**

- 7.1 Энэхүү Гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба гарын үсэг тамгаар баталгаажсан нэмэлт, өөрчлөлтийг Гэрээний салшгүй хэсэг гэж үзнэ.
- 7.2 Аль нэг тал дараах тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй. Үүнд:
  - 7.2.1 Нөгөө тал гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол.
  - 7.2.2 Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл 30-аас дээш хоногоор үргэлжилсэн бол.
  - 7.2.3 Гэрээ болон хуульд заасан бусад үндэслэл.
- 7.3 Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахаар бол нөгөө талдаа ажлын 10 /арав/ хоногийн өмнө бичгээр мэдэгдэж, гэрээ цуцлах болсон үндэслэлийг тодорхой дурдана.
- 7.4 Аль нэг тал гэрээний үүргээ биелүүлээгүйгээс болж гэрээг нэг талын санаачилгаар цуцалсан бол гэрээ цуцалснаас үүдэн нөгөө талд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцаж төлнө.
- 7.5 Талуудын бүтэц, удирдлага өөрчлөгдөх нь гэрээг дуусгавар болгох, цуцлах үндэслэл болохгүй.

### **НАЙМ. БУСАД**

- 8.1 Талуудын удирдлага, өмчлөгч өөрчлөгдсөн нь энэхүү гэрээг цуцлах, өөрчлөх үндэслэл болохгүй. Маргаантай асуудал гарвал талууд хамтарч хэлэлцэн шийдвэр гаргана. Талууд шийдэлд эс хүрвэл Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу холбогдох шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 8.2 Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Гэрээ байгуулах үед Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 8.3 Талууд энэ гэрээнд шаардагдах эсвэл зөвшөөрөгдсөн бүх мэдэгдлийг бичгээр, шуудан эсвэл и-мэйлээр мэдэгдэнэ. Талуудын сонгосон баримтын хэлбэрийг хүчин төгөлдөр, албан ёсны баримт гэж үзнэ.
- 8.4 Гэрээг адил хүчинтэй 2 /хоёр/ хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Худалдагчийг төлөөлж:**

.....

.....

Утас: 976- 99152299

e-mail: [urtnasan.sh@tnc.mn](mailto:urtnasan.sh@tnc.mn)

Хаяг: Хан-Уул дүүрэг, 11-р хороо,  
Ар зайсан гудамж, Энглиш Гарден #2  
Улаанбаатар 17028, Монгол улс

**Худалдан авагчийг төлөөлж:**

.....

...../...../

Утас: +976 .....

e-mail: [.....](mailto:.....)

Хаяг:  
.....  
.....